

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА Б.ГАНЗОРИГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/ д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн дууссан хугацаа	Биелэ лтийн хувь
					Хүрсэн түвшин (биелэлт)		5		
1	2	3	4					6	7
<b>Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах</b>									

1	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.1.26.Гадаад худалдааны цахим нэг цонхны системийг бий болгох/	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бусад төрийн байгууллагатай шаардлагатай мэдээлэл солилцох сервис хөгжүүлэлт хийнэ.	<p>Эдийн засаг, хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/184 тушаалаар "Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тухайн ажлын хэсэгт Гаалийн ерөнхий газрын дэд дарга Б.Ганзориг, ГУАБ Н.Мөнхзул, ГУБ 3.Алтанхуяг нар орж ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>2024 оны 3 дугаар сарын 21ны өдөр "Гадаад худалдааны цахим нэг цонх"-ны бүх оролцогч талуудыг оролцуулсан уулзалтыг ХҮСБНТ-ийн нэгжээс зохион байгуулсан. Уг уулзалтад 19н байгууллагын 40н оролцогч оролцсоноос Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван, МТГ-н ГУАБ Н.Мөнхзул нар оролцсон.</li> <li>Азийн хөгжлийн банктай хамтран Хилийн үйлчилгээг сайжруулах бус нутгийн төслийн цахим нэг цонх хариуцсан гадаад зөвлөх Training on single windows data harmonization, Training on single window business process reengineering сургалтуудыг 2024.03.21-нд 14:00-18:00, 2024.03.22-нд 09:00-17:00-ын хооронд ГЕГ-ын 9 давхарт зохион байгуулсан. Тус сургалтад ЗББНДБ-ын нийт 18 албан хаагч оролцсон.</li> <li>"Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаан 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан. Тус хуралдаанд МТГ-ын ГУАБ Н.Мөнхзул оролцсон.</li> <li>Олон улсын цахим нэг цонхны зөвлөх Эва RIBS, BEST 2 төслийг нэгтгэсэн Англи хэл дээрх (АХБ-ны формат бүхий)</li> </ul>	01.01-06.05	100
---	---	-------------------------	---	---	---	-------------	-----

					ажлын даалгаврыг ЦНЦ-ны ажлын хэсэгт ирүүлсэн. Төслийн нэгжээс Монгол хэлээр хөрвүүлсэн ба ажлын хэсгийн гишүүд уг ажлын даалгавартай танилцсан. Ажлын даалгаврыг 6-р сардаа багтаан батлуулахаар ажиллаж байна.		
<b>Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх</b>							
2	Мэдээллийн нэгдсэн санд дүн шинжилгээ хийж, өгөгдлийг боловсруулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	<p>1.Хилийн үйлчилгээг сайжруулах бус нутгийн төслийн (RIBS) хүрээнд хийгдсэн гаалийн мэдээллийн системийн шинэчлэлийг бүрэн нэвтрүүлэх, баталгаат засварын хугацаанд сайжруулалт хийхэд гүйцэтгэгч компанийтай хамтран ажиллах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2.Гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг техник, сүлжээ болон программ хангамжийг боловсронгуй болгох, өгөгдлийн сан болон програм хангамжийн лицензийн шийдлийг судалж, санал боловсруулсан байна.</p>	<p>1. Хилийн үйлчилгээг сайжруулах бус нутгийн төслийн (RIBS) хүрээнд хийгдсэн гаалийн мэдээллийн системийн шинэчлэлийг бүрэн нэвтрүүлэх, баталгаат засварын хугацаанд сайжруулалт хийхэд гүйцэтгэгч компанийтай хамтран ажиллах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>1) Бүрдүүлэлтийн дараах шалгалтын системтийн бизнес процессын нэмэлт өөрчлөлт</p> <p>2) Тээврийн хэрэгслийн бүртгэл нэмэлт өөрчлөлт</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хил дээрх машины хүсэлт дээр барааны мэдээлэл бүртгэх</li> <li>- Хангийн дахь гаалийн газрын тээврийн бүртгэл автоматаар үүсгэх тохиргоо өөрчлөлт</li> </ul> <p>3) Манифестын нэмэлт өөрчлөлт</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дотоодын дамжин өнгөрөх манифестыг бусад байгууллагаас мэдээлэл холбох API функцийн хөгжүүлэлт</li> <li>- Дотоодын дамжин өнгөрөх манифестыг бусад байгууллагаас мэдээлэл татаж мэдээллийг нөхөн бөглөх процессыг хялбаршуулсан.</li> </ul> <p>4) Экспортын мэдүүлгийн нэмэлт хөгжүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төмөр замын захиалгын хуудас мэдүүлгийн системд холбох хөгжүүлэлт</li> <li>- Улсын төсөвт үйлдвэрийн газрын тээврийн гэрээний сервис холбох хөгжүүлэлт хийгдсэн.</li> <li>- Мэдүүлэг дээрх дотоодын дамжин өнгөрөх манифест холбох хөгжүүлэлт</li> </ul> <p>5) Хяналтын бүсийн үлдэгдлийн модуль дээр Улсын төсөвт үйлдвэрийн газрын тээврийн гэрээний сервис холбох хөгжүүлэлт</p> <p>6) Чөлөөт бүсийн дэлгүүрийн системийг холбох API функцийн хөгжүүлэлт</p> <p>7) Татваргүй барааны дэлгүүрийн системийг холбох API функцийн хөгжүүлэлт</p> <p>8) Итгэмжлэгдсэн ААН бүртгэл мэдээллийн процессын нэмэлт өөрчлөлт</p> <p>9) Шуудан илгээмж карго тээвэрлэгчдийн API холболт</p> <p>10) Барааны ангилал урьдчилан тодорхойлуулах хүсэлт</p>	01.01-06.05	100

2. Гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын техник, сүлжээ болон программ хангамжийг боловсронгуй болгох, өгөгдлийн сан болон програм хангамжийн лицензийн шийдлийг судалж, санал боловсруулах ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:
- Дата төвийн сүлжээний дэд бүтэц анх 2009 онд сүлжээний дотоод дамжих дээд хурд 100Megabit байхаар төлөвлөгдсөн ч одоог хүртэл хэрэглэж байгаа учир өгөгдлийн хэмжээ томорч, сүлжээ удаашрах гацалт доголдол үүсэж эрсдэлтэй байдалд хүрч байна. Иймээс дата төвийн сүлжээний бүтцийн тоног төхөөрөмжүүдийг шинэчилж сайжруулахаар Cisco, Fortinet компаниудын монголын зах зээлийг хариуцсан мэргэжилтнүүдтэй тус бүр цахим уулзалт хийж манай байгууллагад нийцтэй тоног төхөөрөмжийн шийдлийн талаарх санал солилцсон ба дата төвийн сүлжээний дэд бүтцийн логик план зургийг сүүлийн үеийн өндөр хурдны 25Gigabit/100Gigabit шилэн кабелийн төлөвлөлттэй байхаар судалгааг гарган Азийн хөгжлийн банк, СХОГ-т хүргүүлсэн.
  - Өгөгдлийн агуулах(Data warehouse) бий болгох, цахим мэдээлэл солилцох(ESB), тайлан мэдээ дашбоард боловсруулах(Tableau) зэрэг програм хангамжийн лицензийн техникийн тодорхойлолтыг гаргаж, АХБ-н хүргүүлж худалдан авалтыг 2024.06 сард хийхээр болсон.
  - Өгөгдлийн сан болон програм хангамжийн лицензийн шийдлийг судалж, КАИС системийн өгөгдлийн сангийн жил бүрийн лицензийн сунгалтын үнийн судалгааг хийсэн.
  - [WWW.GAALI.MN](http://WWW.GAALI.MN) системд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн хүсэлтийн дагуу бүртгэлийг үүсгэж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангасан. Мөн тус систем дээр гарсан байгаа сервер тоног төхөөрөмжүүдэд гарч байгаа алдаа дутагдлыг тухай бүрд нь арилгаж ажилласан.
  - Мэдээллийн аюулгүй байдлын газрын газраас өгсөн зөвлөмж, болон гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын журмын дагуу дата төв, гаалийн нэгдсэн сүлжээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг хийж, хүргүүлэн ажилласан.
  - ЦХХХЯ болон Үндэсний статистикийн хороо хамтран үндэсний хэмжээний нэгдсэн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Их өгөгдлийн сан”-г үүсгэх, түүний суурь мэдээлэл болох “Мета өгөгдлийн платформт”

					bайгуулахаар ажиллаж байна. Уг ажлын хүрээнд гаалийн байгууллагын экспорт, импортын мэдүүлэг, манифест, тээврийн хэрэгслийн бүртгэл зэрэг програмын өгөгдлийн сангийн талбарууд, ангилалын кодны мэдээллийг бэлтгэн хүргүүлж, Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан /http://metadata.app.nso.mn/-д байршуулсан.		
3	Мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, аюулгүй байдлыг хангах, тоног төхөөрөжмийн судалгаа хийсэн байдал.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1.Систем, сүлжээ, серверүүдэд мониторинг хийх, тасралтгүй хэвийн найдвартай ажиллагаа, нууцлал, хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангасан байна. 2.Шаардлагатай тохиолдолд тоног, төхөөрөмжийн холбогдох судалгааг хийх, төлөвлөх, хуваарилах, ашиглалтад хяналт тавих, засвар үйлчилгээ хийнэ.	<p>1. Систем, сүлжээ, серверүүдэд мониторинг хийх, тасралтгүй хэвийн найдвартай ажиллагаа, нууцлал, хадгалалт, хамгаалалт аюулгүй байдал</p> <p>1) Гаалийн нэгдсэн сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-ын 172.21.48.43 хаяг руу гаалийн байгууллагын програм хөгжүүлэх хаягуудыг нэмүүлж, сүлжээний тоног төхөөрөмжүүдэд тохиргоог хийж, ажиллах нөхцөл бололцоог хангаж өгсөн.</li> <li>Шивээхүрэн ГГ-ын сүлжээний холболтыг дамжуулдаг мэдээлэл холбооны сүлжээ компани станцтай холбосон шилэн кабельд гарсан гэмтлийг цаг алдалгүй засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан.</li> <li>Тайлант хугацаанд дамжуулах сүлжээнд гарсан гэмтлүүдийн сүлжээг шилжүүлэх, гаалийн бүрдүүлэлтийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг бүрдүүлж ажилласан.</li> <li>ЗҮГГ-ын ачаа тээврийн цогцолбор, Увс аймгийн Боршоо боомт ашиглалтад орж, сүлжээ зохион байгуулж, шаардлагатай нэмэлт хаягжилтыг шийдвэрлэж ажилласан.</li> <li>Шивээхүрэн, УБГГ, Завхан ГХ, Хөвсгөл ГХ, Гашуунсуухайт ГГ, Ханх дахь гаалийн газруудад гарсан сүлжээний гэмтэл саатал, тасралт, бусад газар хороодоос ирсэн сүлжээний дуудлагуудыг цаг тухайд нь шалгаж гэмтлүүдийг тогтоон засварлаж, сүлжээний тохиргоонуудыг хийж, хэвийн ажиллагаанд оруулсан.</li> <li>Гашуунсуухайт ГГ, Ханги дахь ГГ, УХШИГГ-уудад хяналтын бүсээр зарлагдсан талбайг гаалийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох холболтыг хийж, шуурхай удирдлагын төвөөс тус гаалийн газрын харьяа гаалийн хяналтын бүс, баталгаат агуулах, татваргүй барааны дэлгүүрүүдийн төлөхяналтын камерыг хянах нөхцөл бололцоог хангаж ажилласан.</li> <li>ШХГГ-т ачаа тээврийн шалган нэвтрүүлэх цогцолборт ашиглаж байгаа ухаалаг гарцын системийн хэвийн</li> </ul>	01.01-06.05	100

				<p>ажиллагааг хангуулах, нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах зорилгоор ШХГГ-т 2024.04.12-04.17-ны өдрийг дуустал дарга Б.Ганзориг, ГУАБ Н.Сандуйсүрэн, ГУБ Л.Доломжав нар томилолтоор ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Гаалийн байгууллагын төрийн цахим хуудсыг шинэчилж сайжруулах ажлын хүрээнд цоо шинэ дизайн шинэ загвартай цахим хуудсыг <a href="http://customs.gov.mn/">/customs.gov.mn/</a> үндэсний data төвийн түрээсийн хийсвэр сервер дээр байршуулах явцад маш ихээр удах, гацах, зарим тохиолдолд шинээр байршуулсан цахим хуудас бүрэн ачааллаж гарч ирэхгүй байх, ердөө 1 цахим хуудас байршуулахад бүтэн 3~5 ажлын өдөр зарцуулж байгаа нь бидний шаардлагад нийцэхгүй байгаа тул үндэсний data төвд хүсэлт тавьж гаалийн байгууллагын өөрийн сервер дээр нүүлгэн шинээр ажиллах орчин бэлдэн байршуулж ажиллуулсан бөгөөд гаалийн газар 19 хороо тус бүрдээр цахин хуудсыг байршуулхад хамгийн ихдээ 20~40 минутанд хуулж байршуулдаг болсон ба тус системийг өөрийн data төвд байршуулах нь нөөцлөлт архивийг өдөр тутам хийж болдог болсон.</li> </ul> <p>2) Data төвийн өргөтгөл шинэчлэл, хэвийн найдвартай ажиллагааг хангах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Дата төвийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хангах үүднээс өдөр бүр тоног төхөөрөмжүүдийн найдвартай байдлыг шалгаж, ажиллагааг хянан ажиллаж байна. Data төвийн хөргөлтийн тоног төхөөрөмжүүд гацах, халах зэрэг асуудлыг шийдвэрлэсэн.</li> <li>Дата төвийг аваарын үед тэжээлээр хангах зориулалттай нөөц дизель станцын техникийн ээлжит урсгалд засвар үйлчилгээг хийж бэлэн байдлыг ханган, өдөр тутмын хяналтыг хийсэн.</li> <li>Дата төвийн хөргөлтийн төхөөрөмжид гарсан техникийн гэмтлийг цаг тухайд нь яаралтай арга хэмжээ авч оношлон эвдрэлтэй сэлбэг хэрэгслийн судалгааг хийж удирдлагуудад танилцуулан, шаардлагатай эд анги сэлбэгүүдийг шинээр худалдан авч нийлүүлэгч компаниар засвар үйлчилгээг хийлгэсэн.</li> <li>ГЕГ болон бусад гаалийн газар хороодын цахим хуудсыг өөрсдийн сервер лүү зөөх, мөн стандартыг хангасан шинэ загварыг тус бурийн домайн хаяг дээр суулгаж хариуцсан ажилтануудад Админ эрхийг нээж өгсөн бөгөөд заавар зөвлөгөөг тогтмол өгч хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.</li> </ul>	
--	--	--	--	--	--

2. Шаардлагатай тохиолдолд тоног, төхөөрөмжийн холбогдох судалгааг хийх, төлөвлөх, хуваарилах, ашиглалтад хяналт тавих, засвар үйлчилгээ хийх
- Замын-Үүд боомтын ачаа тээврийн шинэ шалган нэвтрүүлэх цогцолбор ашиглалтад оруулахтай холбогдуулан тус боомтын сүлжээний дотоод зохион байгуулалтыг шинэчлэн, хилийн хяналтын байгууллагуудаас тусгаарлан шинэ сүлжээний дэд бүтцийг шинээр хийж дуусган сүлжээний төхөөрөмжүүдийг суурилуулж холболт, тохиргоог хийж, тус боомтын шинэ цогцолборын барилгыг ашиглалтад оруулсан.
  - Замын-Үүд гаалийн газрын Зорчигч, ачаа тээврийн шалган нэвтрүүлэх цогцолбор, Гашуунсухайт боомтын ачаа тээврийн шалган нэвтрүүлэхэд ашиглаж байгаа ухаалаг гарцын тоног төхөөрөмжүүдэд системийн шинэ хувилбар суурилуулж, бүрэн тест хийж, тоног төхөөрөмжүүдийн шалгах талаарх сургалтыг байцаагч нарт оруулж, гарын авлага бэлдэж, сургалтыг зохион байгуулж ажилласан.
  - Замын-Үүд гаалийн газрын Зорчигч, ачаа тээврийн шалган нэвтрүүлэх цогцолбор, Гашуунсухайт боомтод суурилуулгадаж байгаа 129 ухаалаг гарцын тоног төхөөрөмжүүдэд 2.0 хувилбарыг шинэчилж, гарцуудад шинээр системийг суулгаж ажиллагаанд оруулсан. Ухаалаг гарцын системийн ашиглах, тоног төхөөрөмжийн ажиллаж байгаа шалгах технологи ажиллагааны зааврыг боловсруулах, гарцуудад байрлуулсан.
  - ГЕГ-ын ЗББНДБ-уудын компьютер, техник тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах ажлын хүрээнд нийт 180 албан хаагчдын компьютеруудын дагалдах тоног төхөөрөмж болон сүлжээнд тохиргоог засвар үйлчилгээ хийснээс
    - 35 албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж буй компьютерын үйлдлийн системийг дахин шинэчилж, хэрэглээний програм хангамжуудыг суулгасан.
    - 60 принтер хувилах төхөөрөмжид тохиргоо засвар үйлчилгээг хийсэн,
    - Дотоод сүлжээний холболт, гэмтэлтэй холбоотой 82 дуудлага ирсний дагуу цаг тухайд нь засвар үйлчилгээг хийж ажилласан.
    - Гаалийн газар хороодоос компьютер техник хэрэгсэлтэй холбоотой 135 дуудлагыг хүлээн авч онлайнаар заавар зөвлөгөө өгсөнөөс системийн гэмтэл 61, программын тохиргоо 37, принтерийн

				<p>тохиргоо 18 дуудлагууд ирснийг цаг тухайд нь засвар үйлчилгээг хийж, заавар зөвлөгөөг өгч ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Системийн хэмжээнд 670 албан хаагчдын компьютерт вирусийн эсрэг ESET програмыг суулгасан.</li> <li>• Газар хороодын төлөхяналтын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах тог тогтвортжуулагч гэмтлийг тодорхойлж, засварлуулах боломжгүй төхөөрөмжийн судалгааг хийж, СХОГ хүргүүлэн ажилласан.</li> <li>• Газар хороодод ашиглаж байгаа сүлжээ, сервер бусад дагалдах тоног төхөөрөмжүүдэд тогтмол хяналтыг тавьж, эвдрэл гэмтлийг тодорхойлж, шаардлагатай сэлбэг хэрэгслийн судалгааг хийж, ажилласан.</li> <li>• ГЕГ-ын газар, хэлтсийн хэрэгцээ шаардлагын дагуу шаардлагатай компьютер техник хэрэгсэл, сэлбэгийн судалгааг гаргаж ИТААЯА-д хүргүүлэн ажилласан.</li> </ul>			
4	Программ хангамжуудыг шинээр боловсруулах, хөгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	<p>1.Захиргаа дотоод ажлын системийн нэмэлт хөгжүүлэлт болон засвар өөрчлөлтүүдийг ЗББНДБ-ын дотоод зурvasын дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>2.Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийн шинэчлэх, сайжруулах хөгжүүлэлтийг ЗББНДБ-ын дотоод зурvasын дагуу хийж гүйцэтгэнэ.</p>	<p>1. Захиргаа дотоод ажлын системийн нэмэлт хөгжүүлэлт болон засвар өөрчлөлт</p> <ul style="list-style-type: none"> <li>• СХОГ-тай хамтран Дүрэмт хувцасны програмыг хэрэглээнд нэвтрүүлэн, шаардлагатай засвар өөрчлөлтийг тухай бүрт хөгжүүлэн ажилласан. Тайлант хугацаанд тус програмаар 1832 дүрэмт хувцасны хүсэлтийг албан хаагчид ирүүлсэн байна.</li> <li>• Хүний нөөц &gt; Анкет цэсэд дараах хөгжүүлэлтийг хийсэн. <ul style="list-style-type: none"> <li>- Хүсэлт &gt; Үргэлжлүүлэн ажиллуулах цэсэнд шилжин явах болон үргэлжлүүлэн ажиллах хүсэлтийн жагсаалтыг эксел файлруу хөрвүүлэх боломжоор хангасан.</li> <li>- Тайлан судалгаа &gt; Шилжилт хөдөлгөөний тайлан цэsnээс хэрэглэгчийн мэдээллийн дэлгэрэнгүй хуудсанд шилжихэд TY-гээр ажиллаж байсан жилүүдийг TT-р тасралтгүй ажилласан жилд тооцохгүй байх тохируулгыг хийж өөрчлөлтийг нэвтрүүлсэн.</li> <li>- Тайлан судалгаа цэsnээс насны хязгаараар хайхгүй байгаа алдааг илрүүлэн засварлаж нэмэлт өөрчлөлтийг системд оруулсан.</li> <li>- Орон тооны бүтэц цэсэнд орон тооны бүтцийг оруулахад гег болон гхх-ны дотоод бүтцийн нэгжийг харуулахгүй алдаа өгч байсныг засварлаж өөрчлөлтийг оруулсан.</li> <li>- Тайлан судалгаа цэsnээс орон тооны судалгаа экслерүү хөрвүүлэх товчийг дараахад хүний нөөц &gt; анкет &gt; орон тооны бүтэц цэсэнд бүртгэгдсэн мэдээлэл болон анкетын мэдээлэлтэй харьцуулан судалгаа хийх</li> </ul> </li> </ul>	01.01-06.05	100

			<p>боловжтой экSEL файлруу хөрвүүлэх боломжтой болсон.</p> <ul style="list-style-type: none"> <li>- орон тооны бүтэц цэснээс жагсаалтыг хайлтын нөхцлийн дагуу экSEL файлруу хөрвүүлэх боломжтойгоор засвар өөрчлөлтийг оруулсан.</li> <li>• Нүүр &gt; бичиг хэрэг &gt; бүртгэл цэснээс дуудлагыг бүртгэх үед шийдвэрлэх гх кодыг оруулах боломжоор хангасан. мөн дуудлагыг бүртгэж хадгалан засварлах тохиолдолд дуудлагын гомдол төрөл нь шинэчилсэн бүртгэлээр бус хуучин бүртгэлээр гардаг байсныг засварласан. Шийдвэрлэх жагсаалт цэснээс экSEL файлруу хөрвүүлэхэд дуудлагын төрөл, гомдлын төрөл нь кодоор гардаг байсанг тухайн кодонд харгалзах нэршлээр нь гаргадгаар засварласан.</li> </ul> <p>2. Гаалийн автоматжуулсан мэдээллийн системийн шинэчлэх, сайжруулах хөгжүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эхлэл (Бүрдүүлэлт) &gt; Гаалийн бүрдүүлэлт &gt; Лаборатори &gt; Дүгнэлт бичих цэсэнд дараах засвар, өөрчлөлтийг хийсэн.</li> <li>- “Гэрээний дугаар”, “Магадлан шинжилгээ хийлгэх шийдвэр”-ийг бичсэн хэрэглэгчийн дугаараар хайх, “Шинжээч” болон “Дүгнэлт бичих ГУБ”-ын дугаараар хайх боломжоор хангаж КАИС системд нэвтрүүлсэн.</li> <li>- Гаалийн лабораторийн дүгнэлтийг нөхөн бичиж буй хэрэглэгч экспортоор гарч буй “Нүүрс” болон “Эрдэс бүтээгдэхүүн”-д АМАТЗ дугаарыг нөхөн бичих боломжоор хангасан.</li> <li>- Лабораторийн дүгнэлтийг нөхөн бичих үед ЛИМС системд оруулсан “АМНАТ”-ын бүртгэлийн КАИС системээс татан авах боломжоор хангасан.</li> <li>- Дүгнэлтийн жагсаалт цэснээс “Дүгнэлтийн дугаар”-ыг дараахад экспортонд гарсан бүтээгдэхүүний жин тоо хэмжээ зөвхөн “Гааль зөвшөөрөв” төлөvt харагдаж байсныг засварласан.</li> <li>- Дүгнэлтийн жагсаалт цэснээс “Дүгнэлтийн дугаар”-ыг дараахад экспортонд гарсан бүтээгдэхүүний жин тоо хэмжээ нь 1 сарын өмнөхөөс бодогдож байгааг тухайн дүгнэлтийн баталгаажсан огнооноос хойш татаж харуулдагаар засварлав.</li> </ul>	
--	--	--	---	--

- Нүүр хуудас (Эрсдлийн удирдлага) > Зорчигч онилох Модуль > Гадаад жуулчны эрсдэлтэй барааны мэдээлэл цэсэнд “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн газар”-аас гаргаж өгсөн сервисын мэдээллийг авч МУ-аас гарч буй гадаад жуулчдын НӨАТ-ын буцаан олголтын талаарх барааны мэдээллийг дуудан авч хянан, шалгах боломжоор хангасан. ХШ ГУБ болон ХШГУАБ-ын эрх бүхий албан тушаалтан тухайн цэсэнд мэдээллийг харах болон татан авч үр дүнгээ оруулан илгээх боломжоор хангасан.
- УХШИГГ-ын хяналтын бүсэд орж буй газрын ачаанд бичигдсэн манифестын мэдээллийн тээврийн баримтыг ашиглан “UPOST” системд оруулсан задаргааг тухайн хяналтын бүсийн ХШ ГУБ татан оруулдаг. Үүнтэй холбоотойгоор тухайн манифестад хавсаргасан тээврийн баримтын урт 12 тэмдэгт байх шаардлагатай байдаг ба МТГ-луу холбогдож солиулдаг байсныг тухайн ГХБ-д ажиллаж буй ХШ ГУАБ тээврийн баримтын тухайн өдрийнхөөр системээс автоматаар солих боломжийг бүрдүүлсэн.
- Эхлэл (Бүрдүүлэлт) > ААН Төрөл, лиценз > Гадаад худалдаа эрхлэгч цэнээс КАИС системд ашиглагдаж буй гадаад худалдаанд оролцогч ААН-ийн мэдээлэлд “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуй нэгж”-ийн мэдээллийг оруулах засварлах боломжоор хангасан.
- 2024 оны 1-р сард 2023 оны жилийн эцсийн гадаад худалдааны статистик мэдээллийг “Статистикийн үндэсний хороо”-той цахим мэдээлэл солилцдог өгөгдлийн санд оруулж тухайн байгууллага татан авах боломжоор хангасан. Мөн 2024 оны 2 болон 3-р сард 2024 оны 1-2 сар хүртэлх гадаад худалдааны статистик мэдээллийг санд оруулсан.
- Татварын ерөнхий газрын системд тээвэрлэгч ААН тээврийн гэрээг оруулан бүртгэж гаалийн мэдүүлэгт хавсаргасан тохиолдолд тухайн тээврийн гэрээний мэдээллийг “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн газар”-аас гаргаж өгсөн сервисийн дагуу хянан шалгах боломжоор КАИС системд өөрчлөлтийг оруулж нэвтрүүлсэн.
- Эхлэл (Бүрдүүлэлт) > Гаалийн бүрдүүлэлт > Экспортын мэдүүлэг > Хилийн биет шалгалт цэсэнд “Илгээх үеийн тээврийн хэрэгслийн дугаар” хайлтыг хүснэгтэд нэмж өөрчлөлтийг оруулсан.

- Экспорт, импортын хилийн хорио цээрийн гэрчилгээ мэдэгдэл системд тайлант хугацаанд Хүнс хөдөө аж ахуйн яам, Мал эмнэлгийн газар болон Хорио цээрийн албандаа импортын эрсдэлийн үнэлгээ хийлгэж зөвшөөрөл авсан нийт 21 ААН-ийн мэдээллүүдийг бүртгэсэн.
- БАҮХ-ээс 2024.04.02-ны өдрийн 02-2.1/68 дугаартай дотоод зурвасаар ирүүлсний дагуу КАИС системийн Үнийн мэдээллийн сангийн мэдүүлгийн бичлэг цэснээс эксел рүү хөрвүүлэхэд Хэлцлийн үнийн бааз руу мэдээлэл оруулсан гаалийн улсын байцаагчийн хувийн дугаарыг гаргах боломжтой болсон.
- СДШХ-ээс ирүүлсэн дотоод зурвасын дагуу өдөр бүрийн мэдээг гарган Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам болон удирдлагуудад хүргүүлж ажилладаг. Уг мэдээг бямба, ням гаригуудад гаргахаа больсон боловч амралтын өдрүүдийн мэдээг нөхөж өгөх шаардлага тавигдаж байна. Иймд өдөр бүрийн мэдээ гаргадаг КАИС системийн тайлан цэсний “Импорт, экспортын зарим барааны мэдээ” болон “Экспортын статистик мэдээлэл” тайлангуудад он, сар, өдөр сонгодог өөрчлөлтийг хийж өгнө үү гэсний дагуу өөрчлөлтийг хийж гүйцэтгэсэн.
- Барааны ангиллын шийдвэрийн сан системд харьяалагдах Гомдол шийдвэрийн санг барааны ангилал, үнэлгээний хэлтсийн хүсэлт гаргасны дагуу тухайн санг үүсгэж байгаа байцаагч л зөвхөн засах шинэчлэх боломжтой болгож, ангиллын кодыг үндсэн мэдээлэл, анхан шатны шийдвэр болон ГЕГ-н шийдвэр хэсэгт тус тусад нь оруулах боломжтой болгож санг үзэж мэдээлэл авч байгаа бусад байцаагч нар илүү ойлгомжтой болгож сан үүсгэж боломжтой болгов. Мөн УСХ-ны шийдвэрийн сан, БТКУС урьдчилан тодорхойлсон шийдвэрийн сан харагдах байдал буюу UI хэсгийг дахин сайжруулж засвар хийж оруулав. Гаалийн бүрдүүлэлтийн Лабораторийн дүгнэлтийн дэлгэрэнгүй харах хуудасны В хэсэг буюу Шинжилгээний үр дүнгийн барааны жагсаалт хэсгийг Алтанхуяг байцаагч үүрэг өгсний дагуу дүгнэлтийг цаасан хэлбэртэй адил болгож дахин хөгжүүлэлт хийж оруулав.
- Системийн хэмжээнд Замын-Үүд болон Сайншанд дах гаалийн газрын архивын хуучин систем болох ARMS програмын бааз нь Архивын төв газрын сервер дээр байршсан бөгөөд хөгжүүлэгч байгууллага хандах боломжгүй учир архивын ерөнхий газарлуу бичиг явуулан зөвшөөрөл авахаар ажиллаж байна. Мөн бусад гаалийн газар хороодын архивын систем ашиглах тухай заавар

			<p>зөвлөгөөг цаг тухайд нь өгч хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эхлэл (Бүрдүүлэлт) &gt; Татварын хувь хэмжээ &gt; Барааны тариф &gt; Импортын тариф, хувь хэмжээ цэснээс БТКУС-ын дэлгэрэнгүй рүү орж тарифын хэм, хэмжээг бүртгэх үед тарифын оруулах хүснэгт засварлах боломжгүй байсныг шалгаж засварлан оруулах боломжоор хангаж нэвтрүүлсэн.</li> <li>• Статистик, дун шинжилгээний хэлтсээс сар бүр гадаад худалдааны мэдээг тухайн сарын 4-ний өдөр гаргаж дуусдаг. Мэдээг гаргасны дараа DW системийн сангаас гадаад худалдааны 1-5 сар хүртгэлх мэдээг өссөн дүнгээр холбогдох мэдээлэл солилцдог байгууллагуудын санд мэдээллийг оруулсан. /Статистикийн үндэсний хороо, Ашигт малтмал газрын тосны газар, Сангийн яам/</li> <li>• Статистикийн үндэсний хорооноос ирүүлсэн гаалийн мэдүүлгийн "Хүлээн авагч улс"-ын мэдээллийг солих ажлын хүрээнд КАИС систем дэх гаалийн мэдүүлгийн үндсэн болон барааны мэдээллийн хүснэгтийг нөөцлөн авч солих шаардлагтай гаалийн мэдүүлгийн харгалзах "Хүлээн авагч улс"-ын мэдээллийг "БНХАУ" болгон солиж DW -ын өгөгдлийн санд хуулах боломжоор хангасан. Энэхүү ажлын хүрээнд холбоотойгоор ГТСМТТ-ын бараа бүртгэлийн нэгдсэн систем рүү тухайн мэдүүлгүүдийг илгээсэн. мөн Статистикийн хорооны цахим мэдээлэл солих өгөгдлийн санд 2022 болон 2023 оны мэдээллийг шинэчлэн оруулж татан авах боломжоор хангасан.</li> <li>• КАИС системийн Импортын манифест / Дамжин өнгөрөх манифест / Дотоодын дамжин өнгөрөх манифестад ХШ ГУАБ нь ХШ ГУБ-ыг дахин томилох боломжоор хангаж системд нэмэлт өөрчлөлтийг оруулж нэвтрүүлсэн.</li> <li>• Статистикийн үндэсний хорооноос 2020 оны гадаад худалдааны мэдээ зөрүүтэй байгааг шалгуулж 2020 оны 1-12 сар хүртэлх гадаад худалдааны мэдээллийг дахин оруулж татаж авах боломжоор хангасан. Мөн энэхүү ажлын хүрээнд статистикийн үндэсний хорооны эрх бүхий мэргэжилтэн нартай холбогдо 2011 оны статистик мэдээллийг дахин шинэчлэн оруулж татаж авах боломжоор хангасан.</li> <li>• КАИС системийн НҮҮР ХУУДАС(Ачаа) &gt; Гаалийн хяналтын бүс &gt; ГХБ-д оруулах &gt; Орох мэдээллийн жагсаалт цэсэнд жагсаалтаас экセル файлруу хөрвүүлэх боломжоор хангаж нэвтрүүлэлтэд оруулсан.</li> </ul>	
--	--	--	---	--

- КАИС системд баталгаажсан лабораторийн дүгнэлтийн хугацаа дуусч тухайн лабораторийн дүгнэлтийг гаалийн мэдүүлэгт хавсаргаагүй тохиолдолд ААН-ийн хүсэлтийг үндэслэн хугацаа сунгах тохиолдолд "Хугацаа сунгасан эсэх" талбарыг сонголтоор оруулж сунгасан тохиолдолд "Тайлбар" заавал бичүүлж авах боломжоор хангаж КАИС системд нэмэлт өөрчлөлийг оруулж нэвтрүүлсэн.
- МАБГ-аас өгсөн санамжийн дагуу КАИС системд ашиглаж буй Javascript сангийн хувилбар хуучных байсан ба халдлагад өртөж болзошгүй гэсэн санамжийн дагуу тухайн санг сүүлийн хувилбараар шинэчилсэн.
- Статистик, дүн шинжилгээний хэлтсээс ирүүлсэн Импорт, экспортын зарим мэдээ цэсэнд Эксел файлруу хөрвүүлэхэд огнооны дагуу өссөн дүнгээр гарахгүй байсанг хайлтын огноогоор хайж гаргах боломжтой болгож засварлаж системд мэдээллийг татан авах боломжоор хангасан.
- Бүрдүүлэлтийн цахим төвөөс өгсөн саналын дагуу КАИС системд "Авто машин өөрөө үнэлэх" цэсийг нэмэлтээр хөгжүүлж тухайн цэсэнд ажиллах эрх бүхий ажилтан нар үнийн сангийн мэдээллийг оруулан илгээж, баталгаажуулах боломжоор хангаж хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.
- Барааны ангилал, үнэлгээний хэлтсээс КАИС программ дахь гаалийн бүрдүүлэлт дэд цэсний үнийн мэдээллийн сан доторх хэлцлийн үнийн бааз дахь жагсаалтыг эксел-рүү гаргадаг болгох, бүртгэсэн губ болон хугацааг гаргадаг болгох програмын даалгавар ирүүлсэний дагуу засвар өөрчлөлтийг хийж, тус хэлтэст хүлээлгэн өгсөн.
- Хорио цээрийн системд импортын эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн 39 аж ахуйн нэгжийн мэдээллийн нэмж оруулав.
- ААН-> Баталгаат агууллах, Бусад баталгаат бүсийн системийн файл сан хэсэгт файлын тайлбар нэмэлт мэдээлэл оруулах боломжтой болгож нэмэлт хөгжүүлэлт хийв.
- Бүрдүүлэлт -> ААН Төрөл, лицензын -> Чөлөөлөлтийн код системийн Бүрдүүлэлтийн жагсаалтыг excel -рүү файл хэлбэрээр мэдүүлэг болон бүртгэлийн жагсаалтыг бүртгэлийн хуудасны дугаараар холбон Мэдүүлэг болон бүртгэлийн жагсаалтыг нэгтгэсэн тайлан гаргах боломжтой болгож нэмэлт хөгжүүлэлт хийв.

- Бүрдүүлэлт -> ААН Төрөл, лиценз системийн Бүртгэлийн хуудас дэлгэрэнгүй хэсгийг PDF файлаар гаргах боломжтой болгов.
- ГЕГ-ын мэдээллийн систем, Зам, тээврийн салбарын нэгдсэн платформ хооронд өгөгдөл дамжуулах, солилцох сервисийг гарган өгсөн.
- Хилийн боомтын захиргааны үйл ажиллагаанд шаардлагатай “Гадаад худалдааны гүйцэтгэл орон, бараа, боомтоор”, “Гол нэрийн барааны динамик статистик мэдээлэл”, “Эрдэс бүтээгдэхүүний импорт, экспортын мэдээлэл” -ийн сервисийг Гаалийн байгууллагын мэдээллийн системээс гарган өгсөн.
- Гашуунсухайт дахь гаалийн газрын харьяа “Смарт эко транс” гаалийн хяналтын бүсийн ухаалаг гарцын е-Тос системийг “КАИС” системтэй амжилттай холбосон.
- Эм эмнэлэгийн хэрэгсэл, хяналт зохицуулалтын газрын мэдээлэл солилцох ажлын хүрээнд тус газраас гаргаж өгсөн өгөгдлийн жагсаалтын дагуу мэдүүлгийн үндсэн болон барааны мэдээллээс нийт 29 төрлийн өгөгдлийг дамжуулах сервисийн хөгжүүлэлтийг бүрэн дуусгаж 6-р сарын 1-нээс үндсэн системд нэвтрүүлсэн. Мөн үүнтэй холбайтоогоор Гааль, татвар санхүүгийн мэдээллийн технологийн газрын УҮГ-н мэдээлэл солилцох сервисд нэмэлтээр лицензийн төрөл, файл, цувралын дугаар, эмийн төрөл, ширхэгийн тоо хэмжээ, эмийн баглаа боодлын тайлбар, системийн дугаар гэсэн 7 өгөгдлийг илгээдэг болгож хөгжүүлэлтийг дуусгасан.
- **Онилгооны програм:**  
Гаалийн ерөнхий газрын дэргэдэх шуурхай хяналтын төвөөс ирүүлсэн “Онилгооны програм”-д нэмэлт өөрчлөлт оруулах саналын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:
  - Зөвлөмжийн тайландаа зөрчил илэрсэн буюу /зөрчилтэй эсэх/-д тийм гэж сонгогдсон тохиолдолд мэдүүлэгт хамаарах зөрчлийн бүртгэлийн дугаар, торгуулийн дүнг автоматаар татдаг болгосон.
  - Нөхөн төлсөн татварын дүнг заавал бөглөх хэсэгт гараар оруулдаг болгосон.
  - Илгээсэн зөвлөмжийн жагсаалт болон тайландаа нөхөн төлүүлсэн болон торгуулийн дүнг харагддаг болгосон.
  - Excel-рүү гаргах үед Зөрчлийн бүртгэлийн дугаар, торгуулийн дүн, нөхөн төлсөн татварын дүн, тухайн

					<p>зөрчлийн үйлдэл болон хуулийн зүйл заалт нэмэлтээр харагддаг болсон.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>Байцаагч хуваарийн програм:</b> <ul style="list-style-type: none"> <li>- Байцаагч хуваарийн программыг шинээр хөгжүүлэх захиалгыг Гааль, татвар санхүүгийн мэдээллийн технологийн газрын УҮГ-т 5-р сарын 1-ны өдөр хүлээлгэн өгсөн. Уг програмын хөгжүүлэлттэй холбоотой тус газарт хөгжүүлэлттэй шаардлагатай тестийн өгөгдлийн сангийн мэдээллүүд болон лавлах сангийн мэдээллүүдийг гаргаж өгсөн. Мөн 5-р сарын 28-ны өдөр Гааль, татвар санхүүгийн мэдээллийн технологийн газрын УҮГ-тай уулзалт хийж, байцаагч хуваарь хийх үед ажилчдын өмнөх сард хаана хэдэн өдөр ажилласан гэх түүхийг татаж авах сервисийг 5-р сарын 31-ний өдөр хөгжүүлж дуусгасан. Уг программыг 7-р сарын 1-нд нэвтрүүлэхээр ажиллаж байна.</li> </ul> </li> </ul> <p>3. Цахим номын сан <a href="http://Elibrary.customs.gov.mn">Elibrary.customs.gov.mn</a></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хэвлэл мэдээлэл сургалт судалгааны төвөөс ирүүлсэн №24/81 дугаартай дотоод албан бичгийн дагуу гаалийн цахим номын санг тус хэлтсийн бодлогын даалгавараар тест сервер үүсгэн интерфайсыг зурж нүүр хуудас болон нэвтрэх, шүүлтүүрийн хэсгийг хийж гүйцэтгэж байна.</li> </ul> <p>4. Дуудлага шийдвэрлэлт:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Тайлант хугацаанд гаалийн газар хороодоос ирүүлсэн компьютерын тоног төхөөрөмжтэй холбоотой, хяналт шалгалт, бүрдүүлэлттэй холбоотой дотоод утсаар мэдээллэсэн /353558/, гаалийн дотоод мессенджерээр мэдээллэсэн /Спарк/, биечлэн ирж мэдээллэсэн, бусад сүлжээгээр мэдээллэсэн нийт 850 дуудлагыг шийдвэрлэсэн.</li> </ul>		
5	Албан хаагчдын чадавхыг бэхжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн асуудал хариуцсан албан хаагчдыг мэдээлийн технологийн чиглэлээр чадавхжуулах боломжийг хангах ажлын хүрээнд:	<p>1. Мэдээллийн технологийн асуудал хариуцсан албан хаагчдыг мэдээллийн технологийн чиглэлээр чадавхжуулах боломжийг хангах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• ГУАБ Н.Мөнхзул нь Дэлхийн гаалийн байгууллагын "BACUDA дата аналитикийн хөтөлбөр"-т хамрагдан, БНСУ-ийн Сувон хотод байрлах Sungkyunkwan их сургуульд Их өгөгдөл, Машин сургалт, Дата аналитикийн чиглэлээр 2023</li> </ul>	01.01-06.05	100

чадавхжуулах  
боломжийг хангаж  
ажилласан байна.

оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 2024 оны 02 дугаар  
сарын 02-ны өдрийн хооронд 5 сарын хугацаатай  
суралцсан.

- 2024.03.01, 2024.03.04-ны өдрүүдэд 09:00-17:00 цагын  
хооронд Novelsoft компаниас зохион байгуулсан Tableau  
Desktop I&II түвшин буюу анхан шатны онлайн сургалтад  
ГУБ Д.Нарангарав хамрагдсан.
  - Монгол Улсын Ерөнхий сайдын “2024 оны эхний хагас жилд  
хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай”  
01 дүгээр албан даалгаврын 5.5 дугаарт авлигатай тэмцэх  
“5Ш” ажиллагааг эрчимжүүлэх, хэрэгжилт, үр дүнг олон  
нийтэд тогтмол мэдээллэх хуулийн дагуу SHILEN.GOV.MN  
системийн сургалтад ГУБ Б.Энх-Амгалан сууж Гаалийн  
байгууллагын Шилэн системийн админаар томилогдон  
ажиллаж байна.
2. Зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын  
албан хаагчдад мэдээ, мэдээлэл олгох сургалтыг зохион  
байгуулах ажлын хүрээнд:
- Азийн хөгжлийн банктай хамтран Хилийн үйлчилгээг  
сайжруулах бус нутгийн төслийн цахим нэг цонх хариуцсан  
годаад зөвлөх цахим нэг цонхтой холбоотой Training on  
single windows data harmonization, Training on single window  
business process reengineering сургалтуудыг 2024.03.21-нд  
14:00-18:00, 2024.03.22-нд 09:00-17:00-ын хооронд ГЕГ-ын  
9 давхарт зохион байгуулсан. Тус сургалтад ЗББНДБ-ын  
нийт 18 албан хаагч оролцсон.
  - Харьяа гаалийн газар, хороодын мэдээллийн технологийн  
ажил үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлага,  
зөвлөмжөөр тухай бүр хангаж, харьяа гаалийн газар,  
хороодын мэдээллийн технологи хариуцсан албан  
хаагчдад мэдээ, мэдээлэл заавар зөвлөгөөг тогтмол өгч,  
ажилласан.
3. Гаалийн байгууллага болон бусад байгууллагаас зохион  
байгуулсан сургалт:
- Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх  
сургалтад 2024 оны 01 сарын 15-ны өдрөөс 03 сарын 14-  
ны өдөр хүртэл мэргэжилтэн Ү.Энхсайхан хамрагдаж  
төгссөн.
  - Үндэсний статистикийн хорооноос ирсэн албан бичгийн  
дагуу “Төрийн нэгдсэн мэдээллийн сан байгуулах бэлэн

					<p>байдал" сэдэвт уулзалтад 2024.03.05-ны өдөр ГУАБ Н.Мөнхзул, ГУБ Д.Нарангаав оролцсон.</p> <ul style="list-style-type: none"> <li>Гаалийн Ерөнхий газрын дэргэдэх сургалтын төвөөс зохион байгуулж байгаа Англи хэлтэй албан хаагч хөтөлбөрт ГУБ М.Оргил 2024.03.13-ны өдрөөс эхлэн 7 хоног бүрийн мягмар, пүрэв гаригуудад хамрагдаж байна.</li> <li>БНХАУ-ын Худалдааны яамнаас зохион байгуулж, Шаньдуун Гадаад худалдааны мэргэжлийн коллежеос гүйцэтгэсэн Цахим худалдааны семинаарт 2024.03.20 – 2024.04.02-ны өдрийн хооронд ГУБ Д.Нарангаав оролцож, сертификат авсан.</li> <li>Зүүн болон Зүүн хойд Азийн үр ашигтай төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хил дамнасан цахим мэдээллийн солилцоог дэмжих төслийн холбоо баригч нарын 2 дугаар уулзалт 2024.04.01-05-ны өдрүүдэд Узбекстан улсын Самарканд хотод, Ази Номхон Далайн Худалдааг Хөнгөвчлөх 11 Дэх Удаагийн Форумын үеэр зохион байгуулагдсан. Энэ уулзалтад МТГ-н ГУАБ Н.Мөнхзул оролцсон. Хурлын тайланг ЗДАС-д байршуулсан.</li> <li>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны АЗ сургалтад 2024.05.14-05.16 хооронд нэгжийн дарга Б.Ганзориг, ГУАБ Н.Мөнхзул, ГУБ Л.Доломжав, Ж.Амарбаяр, Д.Нарангаав, М.Оргил, Ү.Энхсайхан нар хамрагдаж, 2024.05.17-ны өдөр шалгалт өгч тэнцсэн.</li> </ul>		
6	Мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа, хамгаалалт, аюулгүй байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Гаалийн байгууллагын мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа, нууцлал, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. 2. Гаалийн байгууллагын	1. Тайлант хугацаанд дата төв, гаалийн байгууллагын нэгдсэн сүлжээний тоног төхөөрөмжийн өдөр тутмын хэвийн найдвартай ажиллагааг хангаж, ажилласан. Мөн гаалийн байгууллагын 19 газар, хороодыг сервер, сүлжээний тоног төхөөрөмж, хяналтыг тавьж, илэрсэн хортой код "вирус"-ыг илрүүлж, устгуулах арга хэмжээг тухай бурт авч, дата төв, системийн аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна. <ul style="list-style-type: none"> <li>Үндэсний дата төвийн сервер дээр байрлаж байсан Гаалийн ерөнхий газрын болон газар хороодын үндсэн веб сайтуудыг гаалийн ерөнхий газрын дэргэдэх дата төвд зөөж холбогдох тохиргоог системийн админтай хамтран хийж аюулгүй байдал болон хурдан найдвартай ажиллагааг сайжруулж хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна. Гаалийн байгууллагын           </li> </ul>	01.01-06.05	100

				мэдээллийн аюулгүй байдлын техник, сүлжээ болон программ хангамжийн судалсан шийдлийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. 3. Мэдээллийн аюулгүй байдлын газраар мэдээллийн нэгдсэн систем, мэдээллийн сүлжээний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх.	мэдээллийн нэгдсэн системд ашиглагдаж буй системийн өөрчлөлт, нэмэл хөгжүүлэлт болон засвар өөрчлөлтийг оруулахад тест серверт оруулж туршиж үзэн холбогдох нэгжийн зөвшөөрөлтэйгээр системд өөрчлөлтуүдийг оруулж байгаа. <ul style="list-style-type: none"><li>Засгийн газрын 2018 оны 30 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу “Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох төрийн байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-д багтсан байгууллагуудад шаардлага ирүүлсний дагуу гаалийн системийн хэмжээнд ашигладаг интернэтийн урсгалын гарах гарцыг Тагнуулын ерөнхий газрын мэдээллийн аюулгүй байдлын газрын “ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭ”-нд холбож аливаа халдлагын улмаас учирч болох эрсдэлээс давхар хамгаалагдсан.</li><li>Гаалийн байгууллагад ашиглагдаж байгаа үндсэн систем КАЙС, CERP болон цахим шуудан, edoc.ecustoms.mn, чат гэх мэт эрхийг нээх хаах, нууц үг сэргээх ажлыг тухай бүр шийдэж ажилласан.</li></ul>		
7	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Гаалийн байгууллагын үйл ажиллагааны үнэлгээгээр, Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, хуульд заасан хугацаанд багтаан тухай бүр дээд шатны байгууллагад тайланг хүргүүлж ажиллана.	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд “Алсын хараа-2050, Засгийн газрын 2022 оны “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362-р тогтоол, Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 29 дугаар тушаал, Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоол, Монгол Улс 2022 онд эдийн засгийн сэргэлтийг дэмжих бодлого, УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Шинэ сэргэлтийн бодлого”, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 206 дугаар тогтоол хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам зэрэг бодлогын	01.01-06.05	100

8	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Нэгжийн эрсдэлийг танъж тогтоож сан үүсгэнэ.	баримт бичигт тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэж хугацаанд нь тайлагнаж ажилласан.			
9	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Захиргааны зөвлөлийн хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Онлайн, Шуурхайгаас болон бусад хэлбэрээр удирдлагаас өгөгдсөн нийт үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж, тухай бүр тайлагнасан байна.	Мэдээллийн аюулгүй байдлын газраас 2024.02.26-2024.03.01-ны хооронд Гаалийн байгууллагын нэгдсэн сүлжээ болон Дата төвд Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, тайлан ирүүлсэн. МАБГ-аас ирсэн зөвлөмжийн дагуу систем болон сүлжээний тоног төхөөрөмжүүдээр тохиргоог хийж, судалгааг гарган эрсдэлийн санг үүсгэхээр ажиллаж байна.	01.01-06.05	100	
10	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулж, цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид тогтмол бүртгүүлж, гадуур ажилласан, өвчтэй, чөлөөтэй тохиолдол бүрт СЕРП программаар тухай бүр илгээж ажилласан байна.	Тайлант хугацаанд Захиргаа дотоод ажлын системийн Үүрэг даалгаврын програмд оруулсан 13 үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж, биелэлтийг програмд оруулсан.	01.01-06.05	100	
11	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Стратеги	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 100%-д хүрч дуусна. Боомтын барилгын дотоод тохижилт,	Алтанбулаг боомт, Бичиг боомт, Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын ажил дуусаагүй учир тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдээгүй хүлээгдэж байна.	01.01-06.05	100	

	1.4.35. Автоза мын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх/		хаягжилт, тэмдэг, тэмдэглэгээ, тоноглол, гаалийн хяналт шалгалтын зарим тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглалтад хүлээж авах ажлыг зохион байгуулсан байна. 2. Бичигт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 50%- д хүрсэн байна. 3. Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлыг эхлүүлсэн байна.				
12	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.29. IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдын нэгдсэн холбоо (НАРТАМ) - той хамtran TIR-EPD, e- TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох/	Хэрэгжилт, г үйцэтгэлээр	-	ОУАТХ-ны програм хангамжийн багтай цахимаар холбогдох ажиллана.	<p>1. Олон улсын автотээвэрчдийн холбооноос "Международный центр приграничного сотрудничества"-д 2024 оны 5 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан уулзалт, хэлэлцүүлэгт ГУАБ Н.Сандуйсүрэн оролцсон. Уулзалтаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>- TIR горимын тээвэрлэлтийг хөнгөвчлөх механизм;</li> <li>- TIR горимын тээвэрлэлтийг "Ногоон гарц"-аар нэвтрүүлж байгаа туршлага;</li> <li>- БНХАУ-ын гаалийн байгууллагаас ТИР горимын тээвэрлэлтэд тавьж буй хяналттай холбоотойгоор бусад улс орнуудын тээвэрлэлтэд тулгарч байгаа бэрхшээл;</li> <li>- Улс орнуудын автотээвэрчдийн нэгдсэн холбоодын туршлага гэсэн сэдвүүдээр санал солилцсон.</li> </ul> <p>Монголын гаалийн байгууллагыг төлөөлөн оролцож байгаа албан хаагч нар:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсын гаалийн байгууллагын өнөөгийн байдал;</li> <li>• TIR горимын тээвэрлэлтэд тавьж байгаа гаалийн хяналт;</li> <li>• TIR горимын тээвэрлэлтийг ногоон гарцаар нэвтрүүлэх;</li> <li>• TIR-EPD нэвтрүүлэх талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;</li> <li>• Цаашид бидний зорилт гэсэн сэдвээр танилцуулга хийж, бусад орны оролцогч нарт мэдээлэл өгсөн.</li> </ul>	01.01- 06.05	100

					2. Олон улсын автотээвэрчдийн холбоо /IRU/-оос ТИР-ын урьдчилсан цахим мэдээ /TIR-EPD/-г CAIS системтэй холбох ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:		
13	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Системийн хэмжээнд удирдлагууд, хяналт, шалгалт хийж буй гаалийн улсын ахлах	<ul style="list-style-type: none"> <li>4-р сарын 8-нд IRU-н систем болон CAIS системийн хооронд мэдээлэл солилцоход ашиглагдах сервисүүдийн тестийн орчинг зохион байгуулах ажлыг эхлүүлсэн. Тестийн орчинг зохион байгуулах явцад сервис дээрх сертификатийн файл дээр алдаа гарч, мэдээлэл солилцох боломжгүй байсныг 4-р сарын 29-нд шийдвэрлэж хэвийн ажиллагаанд оруулсан. Энэ хугацаанд IRU-гаас илгээх EPD мэдүүлгийг хүлээн авч, хүлээн авсан эсэх хариуг буцааж илгээх сервисийн хөгжүүлэлтийг хийж бэлэн болгосон.</li> <li>5-р сарын 3-нд IRU талаас тестийн 6 EPD015 /EPD мэдүүлэг/ (экспорт – 2, транзит – 2, импорт - 2) илгээснийг амжилттай хүлээн авч, хариу мэдээлэл болох EPD928 /Хүлээн авсан баримт/ -ыг илгээж IRU талд мөн амжилттай хүлээн авсан.</li> <li>5-р сарын 9-нд хүлээн авсан 6 EPD-ийг монголын гаалиас хүлээн зөвшөөрсөн гэх мэдээлэл болох EPD028 /Гаалийн лавлагаа/-ыг IRU руу амжилттай илгээсэн.</li> <li>Үүний дараагаар 5-р сарын 21-нд тус 6 EPD-ын дамжин өнгөрөх зөвшөөрлийн мэдээлэл болох EPD029 /Дамжин өнгөрөх зөвшөөрөл/-ыг илгээсэн.</li> <li>5-р сарын 30-нд экспорт болон транзитын 4 EPD-ын хувьд WSST Exit notification буюу Гарах мэдүүлэг, импортын 2 EPD-ын хувьд WSST Final unloading буюу Ачих мэдүүлгийн 6 мэдээллийг илгээж IRU амжилттай хүлээн авсан.</li> <li>6-р сарын 6-нд тус 6 EPD мэдүүлгийн хилээр гаргах мэдээлэл болох EPD045 /Хилээр гаргах/ мессежийг амжилттай илгээсэн.</li> <li>Цаашид EPD917 - Автомат техникийн татгалзал, EPD016 – EPD татгалзах, EPD014 – Цуцлах хүсэлт, EPD009 – Цуцлах шийдвэр, EPD051 – Дамжин өнгөрөхийг зөвшөөрөөгүй, EPD025 – Лац, ломбо шинэчлэх, EPD140 – Хүлээн аваагүй тээврийн хүсэлт, EPD141 – Хүлээн аваагүй тээврийн мэдээлэл гэсэн мессежүүдийг сервисээр дамжуулан илгээх болон хүлээн авахад бэлэн болгохоор ажиллаж байна.</li> </ul>	01.01-06.05	100

	/1.4.27 Цахим гарын үсгийг гаалийн байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх/		байцаагч, гаалийн улсын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгож тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн систем рүү нэвтрэх, бичиг баримтыг үнэлэх, хяналт, шалгалт хийх, зөвшөөрөл өгөх үйлдлүүд болон гаалийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг болсон байна.	албаны дарга, ГУАБ, ГУБ нарт тоон гарын үсгийн гэрчилгээг 1 жилийн хугацаатай шаруулж хүлээлгэн өгсөн бөгөөд КАИС, СЕПС, СИМС систем рүү нэвтрэн хяналт шалгалтанд ашигладаг болсон. Нийт 540 тоон гарын үсгийн төхөөрөмжийг дээрхи газруудад хүлээлгэн өгсөн. 3. Дорноговь аймгийн Замын-Үүд боомтын зорчигч тээврийн шалган нэвтрүүлэх цогцолборт ашиглаж байгаа ухаалаг гарцын системийн хэвийн ажиллагааг хангуулах, тоон гарын үсгийг нэвтрүүлэх, сургалт зохион байгуулахаар 2024.03.21-03.25-ны өдрийг дуустал 5 хоногийн хугацаанд дарга Б.Ганзориг, ГУАБ Н.Сандуйсүрэн, ГУБ Л.Доломжав, П.Хорлоо нар томилолтоор ажилласан. 4. Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын албан хаагчдын тоон гарын үсгийг нэвтрүүлэх, чөлөөт бүсийн зорчигчийн бараа бүртгэлийн бар код хэвлэгчийг шалгах програмын түвшний тест хийх, сүлжээний тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангахаар ГУБ П.Хорлоо, М.Оргил нар 2024.03.05-03.07-ны өдрийг хүртэл 4 хоногийн хугацаанд томилолтоор ажилласан. 5. Цахим бичиг хэргийн Edoc системийн хувьд тоон гарын үсгээр дотоод албан бичиг болон бусад төрийн байгууллагуудтай DOCX системээр туршилтаар бичиг солилцсон ба тухайн туршилтын үр дүнд зарим нэг засвар өөрчлөлтийг хийх шаардлага гарсан тул тус системийг хөгжүүлэгч "НЬЮ СОНИК ХХК"-д програмын даалгаврыг хүргүүлсэн. 6. Тоон гарын үсгийг УБГГ, ГСГГ, ШХГГ-т олгохоор шат дараатайгаар материалыг хулээн авч, тулгалт хийж байна.			
14	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.35.Автоза мын хилийн боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагата й хамтран ажиллаж,	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1.Хил хамгаалах ерөнхий газартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, солилцох мэдээллийг тохирсон байна.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтаар "Эдийн засгийн хамтын ажиллагааны бус хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд хөгжүүлэх хилийн байгууллагуудын хяналт, удирдлагын нэгдсэн цахим системийг бий болгох ажлын хэсэгт тус газрын ГУАБ Н.Мөнхзул, ГУБ Б.Энх-Амгалан нар орж ажилласан. Төслийн нэгжээс боловсруулсан "Гаалийн Автоматжуулсан Мэдээллийн Систем Каис (Ceps) -ийг Хилийн Удирдлагын Нэгдсэн (Хун) тогтолцоонд холбох өргөтгөлийн модультай болгон шинэчлэх" ажлын даалгавартай танилцаж санал хүргүүлсэн. Уг төслийн тендер Азийн хөгжлийн банкны цахим хуудсанд зарлагдсан.	01.01-06.05	100

	ХИЛЭЭР НЭВТРЕХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙГ НЭГТГЭНЭ./						
--	---	--	--	--	--	--	--

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)				
1	2	3	4	5	6	7			
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	Хууль эрх зүйн мэдлэг, мэдээллээ бататгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны А3 сургалтад 2024.05.14-05.16 хооронд хамрагдаж, 2024.05.17-ны өдөр шалгалт өгч тэнцсэн.	05.14-05.16	100		
2	Албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бие дааж уншиж судалсан байна.	NeoLingo англи хэл сурх апп-г ашиглан англи хэлний чадвараа сайжруулсан.	01.01-06.05	100		

ТАЙЛАН ГАРГАСАН:

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
TYP ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/Б.ГАНЗОРИГ/

2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ БААСАНДОРЖ ОВОГОТОЙ ГАНЗОРИГЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС  
ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ  
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн өрөнхий газар  
Нэгжийн нэр: Мэдээллийн технологийн газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		56.6

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах		13
2	Албан хэрэг хөтлөлтийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх		13
<b>Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо</b>			13

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1	Хандлага, ёс зүй	14
2	Удирдан зохион байгуулах	14
3	Асуудал шийдвэрлэх	10
4	Манлайлах	12
5	Багаар ажиллах	15
6	Харилцаа	15
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7	Мэргэжлийн ур чадвар	13
<b>Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо</b>		13

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	56.6
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13

3 Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	13
<b>Нийт оноо=</b> (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо	82,6

Үнэлгээ өгсөн:

Гаалийн ерөнхий газрын дарга

Төсвийн шууд захирагч

(Р.Отгонжаргал)

2014. 06. 19

(огноо)

Үнэлгээтэй танилцаж,  
зөвшөөрсөн:

Мэдээллийн технологийн газрын даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нэгжийн дарга:

(Б.Ганзориг)

2014. 06. 22

(огноо)